

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 03 сарын 18-ны өдөр

Дугаар ...

БА-078/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

**Хоёр. Ерөнхий мэдээлэл**

- 2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024.05.06 огноо, 0000013 дугаар, БА32024/00068 2024.12.11 огноо, 0001878 дугаар, БА32024/0921
- 2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ХАТ-03/23
- 2.3 Захиалагч: Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг 9091793 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, 21-р хороолол өөрийн байранд, 70174040 холбоо барих утас
- 2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: “Бадрах Инженеринг” ХХК оноосон нэр, 9011439024 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5758467 регистрийн дугаар, БУ17-387/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, үйлдвэрчний эвлэл Талст ХХК-ийн байранд, 88885585 холбоо барих утас,
- 2.5 Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй
- 2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Хатанбаатар ХХК оноосон нэр, 9011039098 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2090473 регистрийн дугаар, 3Т11-473/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 2-р хороо, Сөүлийн гудамж 45/4-601 тоот дугаар, 77228888 холбоо барих утас, info@khatanbaatar.com цахим хаяг;
- 2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг оноосон нэр, 6069001220 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9091793 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Сонгинохайрхан дүүрэг, 19 дүгээр хороо, 21-р хороолол, өөрийн байранд, 70174040 холбоо барих утас, [info@shdne.ub.gov.mn](mailto:info@shdne.ub.gov.mn) цахим хаяг;

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:


Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:


- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.



3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:




Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо,  
Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн захиалгатай,  
зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн барилга

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн  
эмнэлгийн захирал



(Ц.Олонбаяр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРОО, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 2 ДАВХАР, ХҮҮХДИЙН  
АМБУЛАТОРИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн захиалгатай, зоорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 14:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 16:30 цагт дуусав.

Хяналт шалгалтын  
Барилга Байгууламжийг ашиглалтанд  
оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч  
З.Ганбат
3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч  
Э.Цогзолмаа
4. Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын хэсгийн ахлагч  
Ц.Билигт
5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ахлах инженер  
Д.Сүхбат
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер  
Г.Үүрийнгэгээ
7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн  
Н.Болор-Эрдэнэ
8. Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, хошууч  
Б.Даваасүрэн
9. Барилга хөгжлийн төв, инженер  
Г.Уртнасан
10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч  
Э.Шижиртуяа
11. Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Эрхийг Хамгаалах Байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан  
Б.Даваасүрэн
12. ОСНААУГ БТТөв Дулаан горим тохируулгын инженер  
Б.Багабанд

13. “Хатанбаатар” ХХК-ийн архитектор (Зураг төсөл зохиогч байгууллага)


Г.Ихбаяр

14. Бадрах Инженеринг ХХК-ийн инженер (Гүйцэтгэгч байгууллага)

М.Энхбаатар

15. Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Дэд захирал (Ашиглагч байгууллага)

Б.Баяндалай



#### ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн захиалгатай, зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн барилгын ажлын гүйцэтгэлийг шалган ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **З.Ганбат**:

- Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг 2025 он 01-р сарын байдлаар шинэчлэн чанар стандартад нийцсэн талаар тусгаж үзүүлэх
- Гадна тохижилтын ажлыг гүйцэтгэгч байгууллага зүгшрүүлэх хугацаанд хийж гүйцэтгэн дуусгах, ногоон байгууламж нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах. Гадна шугам сүлжээний үеийн е/т үзүүлэх
- Зөвшөөрөлгүй эхлүүлсэн зөрчилд хариу тайлбар өгөх /Гүйцэтгэгч байгууллага/

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**:

- Өрөөнүүдийн доторх коллекторийн босоо шугамыг зэврэлтээс хамгаалах будгаар будаж фото зургаар баталгаажуулж, шалгуулах
- Өрөөнүүдийн АС-н системийн решотка зөв суурилуулж фото зургаар баталгаажуулж, шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын хэсгийн ахлагч **Ц.Билигт**:

- Шинэ хэрэглэгчийн сүлжээнд залгах зөвшөөрлийн бичиг
- ЦЭХ-ээр хангах гэрээ
- Дизель генераторийг АЗТБ-д бүртгүүлэх
- Дизель генераторыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн акт
- Давхрын самбаруудад бирк, схем, плакат
- Ерөнхий самбарт бирк, схем, плакат
- Аянгын хүрээг зургийн дагуу гүйцэтгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ**

- Цэвэр уснаас сорьц өгч дүгнэлтийг шалгуулах /НЭМГ-т хүсэлт өгч, нян хими физик 2 үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлэх
- Дотор цэвэр бохир усны шугамыг ил далд ажлыг холбогдох байгууллагын ажилтнаар баталгаажуулж шалгуулах
- ОСНААУГ-тай байгуулсан гэрээ шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ**:

- Дотор холбоо дохиоллын ил далд ажлын актуудыг нөхөн үзүүлэх /захиалагч ашиглагчаар баталгаажуулах/
- Давхрын самбаруудын сүлжээний утсыг хаягжуулах
- Камерийн хяналтын төхөөрөмжүүдийг цоожтой раканд байршуулах
- Гадна холбооны акт нөхөн үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын байцаагч, хошууч **Б.Даваасүрэн**:

- Гадна ил далд ажлын фото, акт дүгнэлт үзүүлэх
- Галын дохиоллын систем шалгасан акт фото зураг, зааварчилгаа, хамгаалах таг авах
- ГК холбох тотго, хомут солих, ус тавьж шалгах
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж байршуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв, инженер **Г.Уртнасан**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөрийг төлөх
- Гадна довжоог батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Ус зайлуулах хуванцар яндан хоолойг төмөр болгож солих
- Шилэн хаалгануудад анхааруулга наалт наах
- Өрөөнүүдийн хагарал цууралт засварлах
- Зоорийн давхар руу орох аваарын гарцын шатанд хамгаалалт хийх
- 1'-1 тэнхлэг дагуу гадна довжоонд хашлага бариул хийж гүйцэтгэх
- Давхар дундын шатны хашлага төслийн дагуу хийх
- Өөрчлөлтийн зураг баталгаажуулж, зохигчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Э.Шижиртуяа**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товёог үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн**

- Гадна авто машины зогсоолдл ХБИ-ий автомашинд зориулсан зогсоолыг стандартын дагуу хийх /босоо тэмдэглэгээтэй/
- Тусгаарлах өрөөний орц, гарцанд налуу замыг стандартын дагуу төлөвлөж хийх
- Дотор үүдний шилэн хаалганы онгойлтыг зөв болгох
- ХБИ-ий АЦӨ-ний тусгай тоноглолыг зөв болгож солих
- 2-р давхар луу ХБИ, тэргэнцэртэй хэрхэн яаж зорчих вэ? Тайлбар албан бичиг
- Шатны ханан талд бариул хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Баруун түгээх төв, Дулаан горим тохируулгын инженер **Б.Багабанд**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хатанбаатар ХХК-ийн архитектор (Зураг төсөл зохиогч байгууллага) **Г.Ихбаяр**:

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Бадрах Инженеринг ХХК-ийн инженер (Гүйцэтгэгч байгууллага) **М.Энхбаатар**:

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Дэд захирал (Ашиглагч байгууллага) **Б.Баяндалай**

- Зоорийн болон 2 давхрын гэрлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Давхар бүрийн хуваарилах самбарыг хаягжуулах, схем зураг байршуулах
- Газар хөлдсөн үеийн газардуулга хийлгэх, гзардуулгыг газар гэсэхээр дахин хийлгэх
- Далд ажлын фото зургийг авах
- Цахилгаан схем файлаар авах
- Дизель генераторийг аваартай холбох, дараа нь шалгах
- Гадна дээвэрлүү гарах шатыг стандартад нийцсэн түгжээтэй сунадаг шат хийх
- 2 давхрын EXIT гэрлийг тэжээлтэй болгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Дулаан сүлжээ, Хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Гадна дулааны худаг цэвэрлэх
- Худаг доторх шугам будаж дулаалах
- Халаах хэрэгсэлд тохируулах хийж тавих

Комисст хүлээж авахад татгалзах зүйлгүй болно.

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БТХ-ийн дагуу гүйцэтгэгч компани чанарын баталгааны албан тоот хүргүүлэх
- Захиалагч тал болох СХДНЭ захиалагчийн нэгдсэн дүгнэлтийг ирүүлэх
- Зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг БНБД 11-04-16 дагуу шинэчлэн бичих
- ХБИ-ий АЦӨ-ний цонхонд харагдахгүй наалт, хуулга наах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн захиалгатай, зорьтой 2 давхар, хүүхдийн амбулаторийн барилгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэж, баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.


танд

Танилцсан:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:  
Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн  
эмнэлгийн захирал



(Ц.Олонбаяр)